

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2025/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn Ариун төгс оршихуй аудит ХХК-ийн Ахлах аудитор: Г.Баялаг Утас: 89023656 Цахим хаяг: ariuntugsorshihuiiaudit@gmail.com Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг:Sanchirmaa@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 23

№

60

танай _____ -ны № _____ -т

АЛТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Р. НАРАНЦАЦРАЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монголын цахилгаан холбоо ХХК-иас 35,386.00 мянган төгрөгөөр утасгүй дотоод сүлжээ байгуулах ажил хийгджээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын А/80 дугаар тушаалын дагуу математик, англи хэлний цахим сургалтын хөтөлбөр хэрэгжиж гэрээний дагуу патентын эрхийн төлбөр болох 3,759.3 мянган төгрөгийг шилжүүлж шууд зардлаар тайлагнасан байна.

8225020152

Бусад асуудал

Боловсролын газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 11 зорилт 52 арга хэмжээний хэрэгжилт 95.9 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ГҮНЖИДМАА

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр).....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр).....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)....	8
2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр).....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	271,917,617.08	276,147,715.65
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	147,257,685.38	107,124,526.90
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	147,257,685.38	107,124,526.90
31210	Төгрөг	147,257,685.38	107,124,526.90
31211	Төрийн сангийн харилцах	147,257,685.38	107,124,526.90
33	АВЛАГА	1,476,919.52	295,630.27
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,476,919.52	295,630.27
35	БАРАА МАТЕРИАЛ	123,183,012.18	168,727,558.48
35100	Түүхий эд материал	14,292,431.92	17,636,011.72
35110	Тусгай зориулалттай материал	14,292,431.92	17,636,011.72
35400	Хангамжийн материал	108,890,580.26	151,091,546.76
35410	Бичиг хэргийн материал	32,500.00	28,000.00
35420	Аж ахуйн материал	5,462,617.76	4,571,117.76
35440	Түлш, шатах тослох материал	9,344,700.00	7,770,000.00
35460	Хүнсний материал	2,863,517.50	6,197,684.00
35470	Бусад хангамжийн материал	91,187,245.00	132,524,745.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,222,359,570.81	2,382,577,590.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,222,359,570.81	2,382,577,590.85
39200	Биет хөрөнгө	2,096,991,404.19	2,260,917,590.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,129,551,674.51	2,142,402,685.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(298,048,636.25)	(349,236,756.63)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	269,371,343.80	414,825,058.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(120,210,513.13)	(118,728,652.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	191,720,334.90	201,184,972.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(103,183,191.00)	(57,320,107.63)
39217	Ном	27,790,391.36	27,790,391.36
39300	Биет бус хөрөнгө	125,368,166.62	121,660,000.00
39301	Програм хангамж	10,447,600.00	10,187,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,339,433.38)	(9,787,600.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	121,260,000.00	121,260,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,494,277,187.89	2,658,725,306.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,890,071.95	83,269,121.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,890,071.95	83,269,121.00
41300	Өглөг	1,890,071.95	83,269,121.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	79,121.95	0.00
41360	Бусад өглөг	1,810,950.00	83,269,121.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,753,350.00	83,211,521.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	57,600.00	57,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,492,387,115.94	2,575,456,185.50
51	Засгийн газрын хувь оролцоо	2,492,387,115.94	2,575,456,185.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	316,434,125.90	316,434,125.90
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	316,434,125.90	316,434,125.90
51200	Хуримтлагдсан үр дүн	1,763,943,484.60	1,872,850,290.99
51210	Өмнөх үеийн үр дүн	1,624,300,141.87	1,789,781,221.43
51220	Тайлант үеийн үр дүн	139,643,342.73	83,069,069.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	412,009,505.44	386,171,768.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,494,277,187.89	2,658,725,306.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,601,704,161.18	2,079,687,505.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,345,006.00	204,145,905.80
120	Нийтлэг татварын бус орлого	118,345,006.00	204,145,905.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,528,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,633,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,895,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	77,144,900.00	156,358,826.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	24,672,106.00	47,787,079.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,483,359,155.18	1,875,541,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,406,166,100.00	1,743,958,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,406,166,100.00	1,743,958,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,193,055.18	131,583,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,193,055.18	131,583,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,441,727,485.26	1,996,618,436.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,441,727,485.26	1,996,618,436.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,399,311,437.26	1,956,327,131.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	988,999,002.87	1,423,440,120.59
210101	Үндсэн цалин	693,550,749.87	962,299,465.26
210102	Нэмэгдэл	262,345,521.00	414,896,605.33
210104	Урамшуулал	33,102,732.00	46,244,050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,293,800.00	175,990,911.82
210201	Тэтгэврийн даатгал	94,039,900.00	120,014,950.37
210202	Тэтгэмжийн даатгал	11,063,400.00	14,239,084.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,850,700.00	7,119,542.85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,212,700.00	6,923,464.33
210205	Эрүүл мэндийн даатгал	22,127,100.00	27,693,870.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,527,715.18	116,745,646.21
210301	Гэрэл, цахилгаан	7,709,551.18	7,791,096.21
210302	Түлш, халаалт	54,818,164.00	108,252,780.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	701,770.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	300,000.00
2105	Нормативт зардал	35,652,144.90	42,101,343.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	35,652,144.90	42,101,343.50

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,806,600.00	14,325,500.00
210604	Урсгал засвар	5,806,600.00	14,325,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,473,100.00	17,064,743.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,631,500.00	4,865,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,841,600.00	12,199,143.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	159,559,074.31	166,358,865.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,933,183.99	33,226,260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,753,600.00	10,108,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,872,290.32	123,023,805.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,416,048.00	40,291,304.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,416,048.00	37,711,111.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,821,948.00	33,809,690.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,594,100.00	3,901,421.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	2,580,193.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,580,193.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	159,976,675.92	83,069,069.56
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,333,333.19	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	20,333,333.19	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	139,643,342.73	83,069,069.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,500,033,373.18	1,875,541,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,674,218.00	6,765,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,674,218.00	6,765,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,528,000.00	6,765,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,633,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,895,000.00	6,765,600.00
120009	Бусад орлого	146,218.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,483,359,155.18	1,868,776,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,406,166,100.00	1,737,192,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,406,166,100.00	1,737,192,400.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,193,055.18	131,583,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,193,055.18	131,583,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,332,434,814.17	1,915,674,758.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,332,434,814.17	1,915,674,758.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,290,018,766.17	1,874,011,127.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,028,661.00	1,420,890,918.11
210101	Үндсэн цалин	691,580,408.00	877,333,688.95
210102	Нэмэгдэл	262,345,521.00	497,475,610.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	33,102,732.00	46,081,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,293,800.00	177,437,947.00
210201	Тэтгэврийн даатгал	94,039,900.00	120,457,412.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,063,400.00	14,258,633.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,850,700.00	7,129,418.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,212,700.00	7,118,539.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,127,100.00	28,473,945.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,386,455.18	114,233,906.21
210301	Гэрэл, цахилгаан	7,709,551.18	9,025,986.21
210302	Түлш, халаалт	62,676,904.00	103,981,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,226,920.00
2105	Нормативт зардал	32,788,100.00	45,630,863.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	32,788,100.00	45,630,863.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,806,600.00	14,769,500.00
210604	Урсгал засвар	5,806,600.00	14,769,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,473,100.00	17,278,093.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,631,500.00	4,865,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,841,600.00	12,412,493.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,242,049.99	83,769,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,488,449.99	73,463,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,753,600.00	10,306,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,416,048.00	41,663,630.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,416,048.00	39,083,437.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,821,948.00	33,614,337.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,594,100.00	5,469,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	2,580,193.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,580,193.79

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	167,598,559.01	(40,133,158.48)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	26,872,700.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,872,700.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,872,700.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,872,700.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(26,872,700.00)	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	140,725,859.01	(40,133,158.48)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,531,826.37	147,257,685.38
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	147,257,685.38	107,124,526.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,434,125.90	412,190,706.44	1,624,118,940.87	2,352,743,773.21
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	181,201.00	181,201.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,434,125.90	412,190,706.44	1,624,300,141.87	2,352,924,974.21
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(181,201.00)	0.00	(181,201.00)
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	139,643,342.73	139,643,342.73
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,434,125.90	412,009,505.44	1,763,943,484.60	2,492,387,115.94
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	316,434,125.90	412,009,505.44	1,763,943,484.60	2,492,387,115.94
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	25,837,736.83	25,837,736.83
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,434,125.90	412,009,505.44	1,789,781,221.43	2,518,224,852.77
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(25,837,736.83)	0.00	(25,837,736.83)
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	83,069,069.56	83,069,069.56
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,434,125.90	386,171,768.61	1,872,850,290.99	2,575,456,185.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Улсын төсөв (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,889,183,700.00	1,784,091,158.48	105,092,541.52	94.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,889,183,700.00	1,784,091,158.48	105,092,541.52	94.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,843,793,800.00	1,745,007,721.48	98,786,078.52	94.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,495,659,200.00	1,420,890,918.11	74,768,281.89	95.00
210101	Үндсэн цалин	997,693,800.00	877,333,688.95	120,360,111.05	87.94
210102	Нэмэгдэл	469,638,900.00	497,475,610.16	(27,836,710.16)	105.93
210104	Урамшуулал	28,326,500.00	46,081,619.00	(17,755,119.00)	162.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимгэл	186,957,400.00	177,437,947.00	9,519,453.00	94.91
210201	Тэтгэврийн даатгал	127,131,100.00	120,457,412.00	6,673,688.00	94.75
210202	Тэтгэмжийн даатгал	14,956,600.00	14,258,633.00	697,967.00	95.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,478,300.00	7,129,418.00	348,882.00	95.33
210204	Ажилгүйдлийн даатгал	7,478,300.00	7,118,539.00	359,761.00	95.19
210205	Эрүүл мэндийн даатгал	29,913,100.00	28,473,945.00	1,439,155.00	95.19
2105	Нормативт зардал	46,901,900.00	45,630,863.00	1,271,037.00	97.29
210502	Хоол, хүнс	46,901,900.00	45,630,863.00	1,271,037.00	97.29
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,510,900.00	17,278,093.37	10,232,806.63	62.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,867,100.00	4,865,600.00	1,500.00	99.97
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,643,800.00	12,412,493.37	10,231,306.63	54.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,764,400.00	83,769,900.00	2,994,500.00	96.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,452,300.00	73,463,100.00	2,989,200.00	96.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,312,100.00	10,306,800.00	5,300.00	99.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,389,900.00	39,083,437.00	6,306,463.00	86.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,389,900.00	39,083,437.00	6,306,463.00	86.11
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,920,800.00	33,614,337.00	6,306,463.00	84.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,469,100.00	5,469,100.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,889,183,700.00	1,743,958,000.00	145,225,700.00	92.31
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,737,178,400.00	1,737,192,400.00	(14,000.00)	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,737,178,400.00	1,737,192,400.00	(14,000.00)	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	152,005,300.00	6,765,600.00	145,239,700.00	4.45
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,865,600.00	0	4,865,600.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	6,765,600.00	(6,765,600.00)	
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	147,139,700.00	0	147,139,700.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Орон нутгийн төсөв (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төсвийн тохируулга
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	131,583,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	131,583,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	131,583,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	131,583,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	131,583,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131,583,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,003,406.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,233,906.21
210301	Гэрэл, цахилгаан	9,025,986.21
210302	Түлш, халаалт	103,981,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,226,920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,769,500.00
210604	Урсгал засвар	14,769,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,580,193.79

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтай сумын ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд суралцагчдын мэдлэг чадвар, багшийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус байгууллага нь дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Суралцагсдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 100 дугаар тогтоол,

- Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд сургалтын цахим систем нэвтрүүлэх, цахим системд суурилсан хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилтийн хуваарилалтыг батлах тухай” А/380 дугаар тушаал
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг” шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны, төрийн үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох журам”,
- Сангийн сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар “Дотоод албан томилолтын хэмжээ” шинэчлэн батлагдсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,658,725.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 164,448.1 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	147,257.69	107,124.53	-40,133.16
Авлага	1,476.92	295.63	-1,181.29
Бараа материал	123,183.01	168,727.56	45,544.55

Үндсэн хөрөнгө	2,222,359.57	2,382,577.59	160,218.02
Нийт хөрөнгө	2,494,277.19	2,658,725.31	164,448.12
Өр төлбөр	1,890.07	83,269.12	81,379.05
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,492,387.12	2,575,456.19	83,069.07
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,494,277.19	2,658,725.31	164,448.12

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данс байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 107,124.5 мянган төгрөг болж 40,133.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 295.6 мянган төгрөг болж, 1,181.3 мянган төгрөгөөр буурсан нь Монголын цахилгаан холбооноос бэлтгэсэн утасгүй интернэтийн ажлыг хүлээн авсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 168,727.6 мянган төгрөг болж, 45,544.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 229,841.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, аймгийн Боловсролын газраас 9,450.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 38,337.0 мянган төгрөгийг бусад эх үүсвэрээс авч, 232,084.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,382,577.6 мянган төгрөг болж, 160,218.0 мянган төгрөгөөр өссөн.

Тайлант онд 55,377.4 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авч, 227,864.4 мянган төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээс шилжүүлэн авч, 26,776.2 мянган төгрөгийг шилжүүлэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 28 дугаар тогтоолын дагуу 88,956.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,575,456.2 мянган төгрөг болж, 83,069.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Өглөгийн дансны үлдэгдэл 83,269.1 мянган төгрөгийг 81,379.0 мянган төгрөгөөр өссөн нь тогтмол зардал болох түлш халаалт, гэрэл цахилгаан, шатахууны өр үүссэнтэй холбоотой байна.

Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 477,983.3 мянган төгрөгөөр буюу 29.8 хувиар өссөн, нийт зардал өмнөх оноос 554,890.9 мянган төгрөгөөр буюу 38.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 337,791.9 мянган төгрөгөөр өссөн төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,980,089.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт 414,509.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь ажиллагсдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэх 1,889,183.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 131,583.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,889,183.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 131,583.6 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд 1,784,091.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,784,091.2 мянган төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь зардлыг хэмнэн гүйцэтгэлээр зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөг)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,524,200.0	2,524,200.0	-	100.0
2	20233	Хүүхэд хамгаалал	2,631,000.0	2,631,000.0	-	100.0
3	80312	Сургалт семинар	1,795,000.0	1,795,000.0	-	100.0
4	81605	Эрүүл мэндийг дэмжих	2,538,600.0	2,538,600.0	-	100.0
5	81801	Үдийн цай хөтөлбөр	39,920,800.0	33,614,337.0	6,306,463.0	84.2
6	81806	Дотуур байр	251,865,300.0	199,200,737.9	52,664,562.1	79.1
7	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	38,947,300.0	38,947,300.0	-	100.0
8	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	7,582,400.0	5,300,000.0	2,282,400.0	69.9
9	81827	Бичиг үсгийн боловсрол	13,475,200.0	11,967,866.0	1,507,334.0	88.8
10	81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,483,100,700.0	1,443,009,624.2	40,091,075.8	97.3
11	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	36,693,300.0	36,136,310.0	556,990.0	98.5
12	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчныг сайжруулах			-	#DIV/0!
13	81848	Сурах бичгийн түрээс	4,867,100.0	4,865,600.0	1,500.0	100.0
14	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	3,242,800.0	1,560,583.4	1,682,216.6	48.1
		Дүн	1,889,183,700.0	1,784,091,158.5	107,124,526.9	94.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дүгээр сарын 10-ний өдрийн хооронд аудитор Р.Оюунбат, гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитор С.Санчирмаа аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 4 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2,846,831.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 42,702.5 мянган төгрөгөөр тогтоосныг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь байр ашиглалттай холбоотой зардлыг 198.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 340,977.1 мянган төгрөгийн 21 мэдээллээс, цалингаас бусад 5 саяас дээш орлогын гүйлгээний 340,977.1 мянган төгрөгийн 21 гүйлгээ бүрэн байршуулж, хэрэгжилт 97.5 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 144,211.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт (мянган төгрөг)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	144,211.7	3	144,211.7	100.0
Нийт дүн	3	144,211.7	3	144,211.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Дараагийн аудитаар “Эдүтэн”, “Пийрсон” хөтөлбөрийн хэрэгжилт, утасгүй дотоод сүлжээ байгуулах ажлын хэрэглээ гэрээний хэрэгжилтийг шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Аудитаар 43,671.5 мянган төгрөгийн алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайланд 43,671.5 Мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 4,155.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,155.9 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

1. Эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлээс даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлд 3,420.4 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Санхүүгийн ажилтанд, хууль тогтоомжид зааснаас 735.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Алтай сумын Ерөнхий боловсролын сургууль	Мөнгөн гүйлгээний тайланд 43,671.5 Мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй	1	43,671.5	-	-	1	43,671.5	1	43,671.5	-	-	-	-
Дүн		1	43,671.5	-	-	1	43,671.5	1	43,671.5	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудита д хамраг дсан байгуу лагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1		3	4	5	6	7	8	9	10	11	12
Алтай сумын Ерөнхий боловсролын сургууль	Санхүүгийн ажилтанд хууль тогтоомжид зааснаас 735.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон.	1	735,5	-	-	1	735.5	-	-	-	-
	Эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлээс даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлд 3,420.4 мянган төгрөгийг зарцуулсан	1	3,420.4	-	-	1	3,420.4	-	-	-	-
Дүн		2	4,155.9	-	-	2	4,155.9	-	-	-	-



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

20 25 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/65

24725434

Алтай хот

ГАА - 2025 /144/ КА - СТА - ТМЗ
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хлйсэн Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

- Эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлээс даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлд 3,420,400.00 (гурван сая дөрвөн зуун хорин мянга дөрвөн зуун) төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг, 2025 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ц.Наранцацрал) нягтлан бодогч (Б.Амаржаргал) нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

АУДИТЫН МЕНЕЖЕР
"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ" ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Г.Баялаг

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Г.БАЯЛАГ



¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол, 1402 тоот.

8225040543